




ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

MSE: 

2023 он



АГУУЛГА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ТУЗ-ИЙН ТОГТООЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ БОЛОН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

1. 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан
2. 2021 оны цэвэр ашгаас хуваарилж олгосон ногдол ашгийн тайлан
3. 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийн мэдээлэл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 65 дугаар зүйлийн 65.1, 71 дүгээр зүйлийн 71.3, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Хувьцаа компанийн хурлын зар хүргэх журмын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 сарын 14-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал /цаашид “Хурал” гэх/-ыг 2023 оны 4 сарын 29-ний өдрийн 10:30 цагт Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Бага тойруу 1, Амарын гудамж, Нийслэлийн Соёлын Төв Өргөөний танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд мэдээлэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг Ард Апп (Ard App) болон цаасан хосолсон хэлбэрээр хэрэгжүүлэхээр зохион байгуулсугай.
4. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2023 оны 3 сарын 31-ний өдрөөр тогтоосугай.
5. Хурлын даргаар Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга О.Одбаярыг, дараах нэр бүхий хүмүүсийг Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр тус тус томилсугай. Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга:

Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах

Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Г.Баярбат

Хуульч Э.Оюун-Эрдэнэ

Хүний нөөц Г.Солонго

Маркетингийн менежер Н.Хандмаа

Мэдээлэл технологийн инженер Н.Бямбасүрэн

Дотоод аудитор П.Бямбасүрэн

Нярав Л.Насанбуян

6. Хурлын тооллогын комиссоор Б. Баттулга (Блүмсбюри Секьюритис ҮЦК ХХК)-ийг сонгон ажиллуулсугай.
7. Хуралд биечлэн оролцоогүй боловч саналын хуудсаар саналаа урьдчилан ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсонд тооцож, саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацааг 2023 оны 4 сарын 28-ний өдрийн 11 цаг 00 минут байхаар тогтоосугай.
8. Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Хувьцаа компанийн хурлын зар хүргэх журмын дагуу Хурлын мэдэгдлийг Хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд мэдээлж, Хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах боломж, нөхцөлөөр хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Г.Баярбат/-д даалгасугай.

ДАРГА

О.ОДБАЯР

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 3 сарын 14-ны
өдрийн 02/23 тоот тогтоолын Хавсралт №1

2023 ОНЫ 4 САРЫН 29-НИЙ ӨДӨР ХУРАЛДАХ АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ

1. 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах тухай;
2. 2021 оны цэвэр ашгаас хуваарилж олгосон ногдол ашгийн тайланг танилцуулах тухай;
3. 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай;

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 3 сарын 14-ны
өдрийн 02/23 тоот тогтоолын Хавсралт №2

САНАЛ АВАХ ХУУДАС (ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №1)

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2023 оны 4 сарын 29-ний өдрийн 10 цаг 30 минутанд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Бага тойруу 1, Амарын гудамж, Нийслэлийн Соёлын Төв Өргөөнд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

Саналын томьёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай	☐	☐	☐

- Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
- Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцох боломжгүй бол компанийн байранд ирэх эсвэл www.arddaatgal.mn вэб сайтаас хурлын материалтай танилцаад энэхүү санал авах хуудсаар урьдчилан саналаа өгч болно.
- Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл олгож, нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2023 оны ... сарын ... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____ (.....)

Хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 3 сарын 14-ны
өдрийн 02/23 тоот тогтоолын Хавсралт №2

**САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №2)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____
Регистрийн дугаар: _____
Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн
Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2023 оны 4 сарын 29-ний өдрийн 10 цаг 30 минутанд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Бага тойруу 1, Амарын гудамж, Нийслэлийн Соёлын Төв Өргөөнд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1. О.ОДБАЯР	_____
2. Г.УЯНГА	_____
3. Ч.ГАНЗОРИГ	_____
4. Б.ЗОЛБОО	_____
5. С.ОРГИЛ	_____
6. Г.ЦОГБАДРАХ	_____

ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1. З.АРИУН	_____
2. Б.БОЛОРЧИМЭГ	_____
3. И.СЭР-ОД	_____
4. Т.БИЛГЭЭ	_____
5. Д.ГАЛХҮҮ	_____
6. З.ОЮУНЦАЦРАЛ	_____

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 3 сарын 14-ны
өдрийн 02/23 тоот тогтоолын Хавсралт №3

АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 3 сарын 14-ны өдрийн 02/23 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах тухай зарлаж байна.

Хурал хуралдуулах газар, өдөр, цаг: 2023 оны 4 сарын 29-ний өдрийн 10 цаг 30 минутанд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Бага тойруу 1, Амарын гудамж, Нийслэлийн Соёлын Төв Өргөөнд хуралд оролцох боломжтой бөгөөд мөн Ард Апп (Ard App) ашиглан хуралд саналаа өгөх боломжтой.

Компанийн оноосон нэр: Ард Даатгал ХК

Хурлын хэлэлцэх асуудал:

1. 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах тухай;
2. 2021 оны цэвэр ашгаас хуваарилж олгосон ногдол ашгийн тайланг танилцуулах тухай;
3. 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай;

Бүртгэлийн өдөр: 2023 оны 3 сарын 31-ний өдөр

Хуралд бэлтгэх явцад Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:

1. 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан;
2. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх Саналын хуудасны загвар;
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
4. 2021 оны цэвэр ашгаас хуваарилж олгосон ногдол ашгийн тайлан;
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл.

Хувьцаа эзэмшигч та 2023 оны 3 сарын 22-ны өдрөөс хойш ажлын өдрүүдэд ажлын цагаар өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандах, эсхүл www.arddaatgal.mn цахим хуудсаар зочлон хурлын материалтай танилцах боломжтой.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1305-1307 тоот

Утас: 7720-0088 (Оператер)

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн
377 дугаар тогтоолоор баталсан
“Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн
хурлын зар хүргэх журам”-ын нэгдүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	Ард Даатгал ХК
Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1305-1307 тоот
Хурал хуралдах өдөр, цаг:	2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр 10 цаг 30 минут
Хурал хуралдах газар /хаяг байршил/:	Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Бага тойруу 1, Амарын гудамж, Нийслэлийн Соёлын Төв Өргөөнд
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн Удирдах Зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2023 оны 3 сарын 14-ны өдөр
Олон нийтэд заралсан огноо:	2023 оны 3 сарын 16-ны өдөр
Бүртгэлийн өдөр:	2023 оны 3 сарын 31-ний өдөр
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, диллерийн компанид хүргүүлэх огноо:	2023 оны 3 сарын 22-ны өдөр
Хүргүүлсэн огноо:	2023 оны 3 сарын 16-ны өдөр
Хурлын дарга:	ТУЗ-ийн дарга О.Одбаяр
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэрс:	Тооллогын комиссын дарга: Б.Баттулга Тооллогын комиссын гишүүд: Г.Нандинэрдэнэ, Г.Гүнбилэг
Баримт бичгийн жагсаалт:	Хавсралтаар
Баримт бичгийн хуудасны тоо:	 хуудас

Хурал зохион байгуулах комиссын дарга



/Г. Цогбадрах/

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

▶ Хурлын ирц танилцуулах Тооллогын комисс)	10:30-10:40
▶ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээх (ТУЗ-ийн дарга О.Одбаяр)	10:40-10:50
▶ Хурлын хөтөлбөр, хэлэлцэх асуудал танилцуулах	
▶ Хэлэлцэх асуудлын жагсаалтын дагуу танилцуулга хийх	10:50-11:50
▶ 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах; (Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах)	
▶ 2022 онд олгосон ногдол ашгийн тайланг танилцуулах; (Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах)	
▶ 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах; (ТУЗ-ийн дарга О.Одбаяр)	
▶ Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох; (ТУЗ-ийн дарга О.Одбаяр)	
▶ Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт	11:50-12:00
▶ Санал авах	12:00-12:10
▶ Санал хураалтын дүнг нэгтгэн, Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах	12:10-12:20
▶ Хурлаас гарсан шийдвэрийг Хурлын дарга танилцуулж, Хурлыг хаах (ТУЗ-ийн дарга О.Одбаяр)	12:20-12:30

Хурлын үргэлжлэх хугацаа: 2 цаг 00 минут

Жич: Шаардлагатай тохиолдолд хурлын хугацааг сунгаж болно.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах тухай;
2. 2022 онд олгосон ногдол ашгийн тайланг танилцуулах тухай;
3. 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай;

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Ард Даатгал компанийн хувьд Монгол улсын компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж холбогдох хууль, тогтоомж, дүрэм журамд заасан шаардлагуудыг ханган Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ) – ноос даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч, үйл ажиллагаагаа явуулж буй (Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар – 2/16) хувьцаат компани юм.


Бидний үйл ажиллагаа нь Иргэний хууль, арилжааны даатгалын холбогдолтой хуулиуд болон Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан даатгалын багц дүрмээр зохицуулагддаг ба тус компани нь даатгалын компанийн хувьд зөвхөн даатгалын үйлчилгээ эрхэлдэг төдийгүй Даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйл болон 49 дүгээр зүйлд заасны дагуу эрх, үүргээ хүлээн ажилладаг юм.


Ард Даатгал ХК нь 2018 онд IPO хийж, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсон бөгөөд Компанийн тухай хууль, Үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржийн үнэт цаас гаргагчид холбогдох дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллаж байгаа билээ.

Тус компани нь 1994 онд Монгол Улсын ууган даатгалын компани болон байгуулагдаж, даатгалын зах зээлд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Өдгөө Монгол Улсын даатгалын салбарт тэргүүлэгч байр суурь бүхий олон улсад болон дотоодод нэр хүндтэй тогтвортой даатгалын үйлчилгээ үзүүлэгч болсон төдийгүй баялаг бүтээгчдийн найдвартай ар тал болон дэмжиж ажилласаар ирсэн нь Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд тодорхой хувь нэмрээ оруулан амжилттай ажиллаж байгааг харуулж байна.



ТҮҮХЭН ТОВЧООН





ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

MSE: 

8,142

Хувьцаа эзэмшигчиддээ

₮1 тэрбум

Ногдол ашиг тараалаа

Хувьцаа эзэмшигчиддээ 1 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваариллаа.

Монгол Улсын 5 том арилжааны банк, мэргэжлийн зуучлагчийн тусгай зөвшөөрөл бүхий 30 гаруй компани, мөн тооны банк бус санхүүгийн байгууллагатай даатгалын зуучлалаар хэд хэдэн төрлийн даатгалын хэлбэрүүдээр хамтын ажиллагаагаа шинэ шатанд гарган, өргөжүүлэх ажлуудыг шат дараатай хэрэгжүүлж байна.

Даатгуулагчийг урамшуулах ажлын хүрээнд иргэд болон байгууллагад даатгалын хураамжийн орлогын хувь хэмжээгээр тооцон АрдКойны урамшуулал олгон ажиллав.



2022 оны турш давхардсан тоогоор нийт 156 байгууллагын 4,680 хүнийг хамруулсан зөвхөн Эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг таниулах, даатгуулсан харилцагчдаа халамжлах, зөвлөгөө мэдээллээр хангах сургалтыг зохион байгуулжээ.



2019 оноос хойш Ковидын улмаас завсарлаад байсан Сингапурын Олон Улсын Давхар Даатгалын Конференц 2022 оны 10 сарын 31-ээс 2022 оны 11 сарын 3-ны өдрүүдэд Сингапур улсад зохион байгуулагдаж манай компанийн төлөөлөл биечлэн оролцож Miller, Swiss Re, Munich Re, Howden, UIB, JB Boda, Gallagher re, Canopus, China Re, Kuwait re зэрэг давхар даатгагч, брокеруудтай уулзаж гадаад хамтын ажиллагаагаа бэхжүүлэв.

Ард Даатгал компанийн стратегийн түнш болох ХБНГУ-ын Аллианц (Allianz) компанийн Сингапур улсад зохион байгуулсан олон улсын сургалт семинарт оролцож бизнесийн хүрээг тэлэх, зах зээлийн хувь оролцоог нэмэгдүүлэх боломжуудыг хэлэлцэж, цаашдын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах суурийг тавьлаа.



Иргэдийн даатгалын боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулж Санхүү Эдийн Засгийн Их Сургуультай хамтран “Даатгалын зах зээлийн сорилт ба шийдэл” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, ерөнхий ивээн тэтгэгчээр оролцсон.

Даатгуулагчийн хамтын ажиллагааны үр дүнгээс хамааруулж харилцагчийн ангилалтай болгосноор даатгалын үйлчилгээг түргэн шуурхай, таатай нөхцөлөөр хүргэх боломжтой болгов.

Монголын Хөлбөмбөгийн холбоотой хамтран ажиллах хүрээнд олон улсын тэмцээнд оролцсон өсвөрийн хөлбөмбөгийн тамирчдыг дэмжин хамтран ажилласан.



Жудо бөхийн өсвөрийн шигшээ багийн тамирчдыг олон улсын тэмцээнд дэмжин хамтран ажиллалаа.



“Даатгал бидний амьдралд” сургалтыг тогтмол давтамжтайгаар олон нийтэд зохион байгуулж иргэдэд даатгалын тухай, түүний ач холбогдлыг таниулахыг зорин ажиллалаа.



Нөхөн төлбөрийн үйлчилгээгээр 7,675 даатгалын тохиолдолтой холбоотой 7.9 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлж өмнөх жилээс 60 гаруй хувийн өсөлттэйгээр даатгуулагчдын өмнө хүлээсэн даатгалын гэрээний үүргээ бүрэн биелүүлж ажиллалаа.

1 хоногт
шийдвэрлэдэг
нөхөн төлбөр

21 тохиолдол

Сүүлийн 3
жилд олгосон
нөхөн төлбөр

17.5 тэрбум ₮

Ахмадын асрамжийн төвд сувилуулж буй ахмадууд болон Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн Эрчимт эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлж буй өвчтөнүүдэд нэн шаардлагатай байдаг асрахуйн хэрэгслүүдийг гардуулан өгснөөс гадна хамт олноо тэргүүлэн ажиллаж буй сувилагч нарт Ардын Тэтгэврийн Данс компанийн Тэтгэврийн хуримтлалыг нээн өгч, ирээдүйгээ өмчлөхөд нь нэг алхмаар ойртууллаа.



Монголын даатгалын салбар үүсч хөгжсөний 82 жилийн ойг тохиолдуулан “Замын хөдөлгөөнд соёлтой оролцъё” үйл ажиллагааг зохион байгуулж, дүрмээ баримтлан замын хөдөлгөөнд оролцохыг жолооч нартаа уриалан, мөн урамшуулан ажиллалаа.



Мөн Улсын Нийгмийн даатгалын санд 500 сая, татварт 1.2 тэрбум төгрөг төлсөн байна.

Ард Даатгал ХК нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд, үйл ажиллагаагаа нээлттэй ил тод явуулан, харилцагч даатгуулагч, хамтрагч түнш байгууллага, олон нийт, ажиллагсдынхаа өмнө бизнесийн ёс зүй, хэм хэмжээг зарчим болгон улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахаар нийт хамт олноороо чармайн ажиллаж байна.

Ард Даатгал компанийн зүгээс харилцагч байгууллагууддаа гэрээний хугацаанд даатгалын тохиолдолд болон эрсдэлийг удирдахад чиглэсэн арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулдаг. Энэхүү ажлын хүрээнд даатгалын үйл ажиллагааны шинжилгээг хагас жил тутамд хийж, учирсан эрсдэлүүдэд харьцуулсан судалгаа гаргаж, түүнд тохирсон зөвлөгөө, сургалт, семинаруудыг тогтмол зохион байгуулсаар байна.

Харилцагч, даатгуулагчдынхаа цаг завьг хэмнэх, эрүүл мэндийг хамгаалах, даатгалын үйлчилгээг илүү ойр болгох үүднээс даатгал хийлгэх болон нөхөн төлбөрийн материал илгээх ажиллагааг Ард Аппаар шийдвэрлэдэг болов.



Ард Даатгал ХК нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд, үйл ажиллагаагаа нээлттэй ил тод явуулан, харилцагч даатгуулагч, хамтрагч түнш байгууллага, олон нийт, ажиллагсдынхаа өмнө бизнесийн ёс зүй, хэм хэмжээг зарчим болгон улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахаар нийт хамт олноороо чармайн ажиллаж байна.

Монгол улсын 21 аймаг, 265 сумдад оршин суугаа иргэдэд санхүүгийн бүхий л төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх, мэдээлэл түгээх зорилгын хүрээнд Ард Санхүүгийн Нэгдлээс хамтран хэрэгжүүлж буй “Ардын Брокер” төсөлд хамтран оролцлоо.

Хамт олны санаачлагаар Цус сэлбэлт судлалын үндэсний төвд ажилчид цусаа хандивлалаа.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ БОЛОН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ


Ард Даатгал ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тоо 2022 оны 12 сарын 31-ний өдрийн тархалтын мэдээнээс харахад 9,515 хүрч хувьцаа эзэмшигчдийн тоо оны эхнээс 636 хувьцаа эзэмшигчээр буурсан бөгөөд буурсан шалтгаан нь хоёроос дээш ҮЦК-д бүртгэлтэй хувьцаа эзэмшигчид дансаа нэгтгэсэн, АСН-с гаргасан хувьцааны багцаар авсан хувьцаа эзэмшигчид зах зээлд нийлүүлсэн зэрэг нөлөөлсөн байна. Энэ онд хувьцаа эзэмшигчдийн дунд орсон томоохон өөрчлөлт нь Мандал Капитал Маркетс ҮЦК-ийн 5.1 хувь буюу 1,269,868 ширхэг хувьцаа эзэмшиж байсан бөгөөд зах зээлд бүрэн нийлүүлсэн бол Би Ди Сек ҮЦК компанийн 2.4 хувь буюу 599,216 ширхэг хувьцаа, Апекс Капитал ҮЦК-ийн 1.4 хувь буюу 358,524 ширхэг хувьцааг тус тус зах зээлээс авч эзэмшиж байна.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

	2021.12.31		2022.12.31		Өөрчлөлт
	тоо	хувь	тоо	хувь	
1 Ард Санхүүгийн Нэгдэл ХК	11,338,675	45.4	11,342,832	45.4	4,157
2 Ардын Тэтгэврийн Данс ХХК	1,316,554	5.3	1,445,289	5.8	128,735
3 С.Оргил	1,164,822	4.7	1,164,822	4.7	-
4 Г.Бат-Эрдэнэ	1,164,822	4.7	1,164,822	4.7	-
5 Н.Мөнхнасан	1,140,742	4.6	1,140,742	4.6	-
6 Энержи Интернэйшнл Капитал ХХК	820,750	3.3	820,750	3.3	-
7 БиДиСек ҮЦК	10	0	599,216	2.4	599,206
8 Ард Кредит ББСБ ХК	368,983	1.5	437,006	1.7	68,023
9 Ард Бит ХХК	414,707	1.7	414,082	1.7	(625)
10 Апекс Капитал ҮЦК	-----	0	358,524	1.4	358,524
11 Үндэсний Хувьчлалын Сан ХОС	342,534	1.4	342,534	1.4	-
12 Бодь Даатгал ХК	212,594	0.9	212,594	0.9	-
13 А.Сүхдорж	203,994	0.8	203,994	0.8	-
14 Ч.Амарбаатар	186,614	0.7	166,000	0.7	(20,614)
15 Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК	1,269,868	5.1	----	0	(1,269,868)
16 Бусад	5,054,331	20.2	5,186,793	20.7	132,462
НИЙТ ДҮН	25,000,000	100.0	25,000,000	100	-
Хувьцаа эзэмшигчдийн тоо	10,151	100.0	9,515	100	(636)

Хувьцааны арилжааны хувьд 2022 онд 2.6 сая ширхэг хувьцаа, нийт 2.4 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн бөгөөд дээд үнэ 1,350 төгрөг, доод үнэ 685 төгрөг хүрсэн бол жилийн арилжааны сүүлийн өдөр 929 төгрөгөөр хаагдсан байна. Ингэснээр 2022 он жилийн эцсийн байдлаар компанийн үнэлгээ 23.2 тэрбум төгрөг болсон байна.

Хувьцааны арилжааны мэдээ



Хаалтын ханш	₮929
Дээд болон доод ханш:	₮636 - ₮1,350
Нийт хувьцааны тоо:	25,000,000
Нийт арилжаалагдсан тоо:	2.6 сая
Нийт арилжааны дүн:	₮2.4 тэрбум
Зах зээлийн үнэлгээ:	₮23.2 тэрбум

EPS:	₮36
BVPS:	₮686
P/E – Үнэ/Ашиг:	25.8
P/B – Үнэ/Дансны үнэ:	1.35



Ард Даатгал ХК
Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 оны 12 сарын 31- ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31- ний үлдэгдэл
Хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	8	814,417	983,100
Даатгалын авлага	9	5,638,403	3,567,406
Бусад санхүүгийн хөрөнгө	10	752,084	1,712,440
Бусад санхүүгийн бус хөрөнгө	11	548,452	946,715
Хөрөнгө оруулалт	12	24,181,282	23,609,898
Даатгалын хөрөнгө	13	3,091,172	1,924,247
Үндсэн хөрөнгө (цэвэр)	14	405,608	2,082,238
Биет бус хөрөнгө (цэвэр)	15	213,093	-
Нийт хөрөнгө		35,644,511	34,826,044
Өр төлбөр ба эздийн өмч			
Өр төлбөр			
Даатгалын өглөг	16	2,220,430	2,265,356
Бусад санхүүгийн өр төлбөр	17	694,789	941,160
Бусад санхүүгийн бус өр төлбөр	18	1,345,534	1,515,332
Орлогд тооцоогүй хураамжийн нөөц	19	11,569,702	8,307,000
Нөхөн төлбөрийн нөөц сан	20	3,134,774	3,401,350
Өр төлбөрийн нийт дүн		18,965,229	16,430,198
Эздийн өмч			
Эзэмшигчдийн өмч	21	5,000,000	5,000,000
Нэмж төлөгдсөн капитал		3,280,854	3,280,854
Дахин үнэлгээний нэмэгдэл		(267,492)	-
Хуримтлагдсан ашиг (алдагдал)		8,665,920	10,114,992
Эздийн өмчийн дүн		16,679,282	18,395,846
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		35,644,511	34,826,044

Уг санхүүгийн байдлын тайланг 2023 оны 3 дугаар сарын 31-нд батлав:

Гүйцэтгэх захирал
Г. Цогбадрах

Огноо: 2023/03/31

Санхүү удирдлага, үйл ажиллагааны
газрын захирал
Т.Батцэнгэл

Огноо: 2023/03/31

Хуудас 13-54-д харуулсан тодруулгууд нь энэхүү санхүүгийн байдлын тайлангийн салшгүй нэг хэсэг болно.



Ард Даатгал ХК
Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 он	2021 он
Даатгалын үйл ажиллагаа			
Даатгалын хураамжийн нийт орлого	22.1	22,315,689	16,462,353
Даатгалын хураамжийн буцаалт	22.2	468,805	570,234
Давхар даатгалын хураамжийн зардал	22.3	4,230,922	2,398,880
Даатгалын хураамжийн цэвэр орлого		17,615,962	13,493,239
Орлогод тооцоггүй хураамжийн нөөцийн өөрчлөлт			
Орлогод тооцоггүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	23	(3,262,702)	(616,900)
Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт	24	662,283	(1,183,631)
Орлогод тооцсон хураамж		15,015,543	11,692,708
Нийт нөхөн төлбөрийн зардал			
Нийт нөхөн төлбөрийн зардал	25.1	7,858,896	4,966,724
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	25.2	254,590	336,403
Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр	25.3	1,574,204	481,603
Нөхөн төлбөрийн цэвэр зардал		6,030,102	4,148,718
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт			
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	26.1	(244,479)	(4,307)
Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт	26.2	(10,437)	397,693
Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт	26.3	(22,097)	284,729
Зардалд тооцсон нөхөн төлбөр		5,753,089	4,826,833
Даатгалын гэрээний зардал			
Даатгалын гэрээний зардал	27	2,590,349	2,153,743
Давхар даатгалын шимтгэлийн орлого	28	143,467	178,127
Хөрөнгө оруулалтын орлого ба олз (гарз)	29	435,828	9,294,759
Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал)		7,251,399	14,185,018
Хүү, эрхийн шимтгэлийн орлого			
Хүү, эрхийн шимтгэлийн орлого		-	370
Бусад орлого	30	191,590	153,227
Ерөнхий ба удирдлагын зардал	31	2,355,406	2,079,967
Борлуулалт, маркетингийн зардал	32	3,796,194	3,532,465
Санхүүгийн зардал	33	13,785	41,580
Бусад зардал	34	202,222	465,276
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	35	(226,860)	4,334
Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		54,106	98,257
Бусад ашиг (алдагдал)		(6,348,771)	(5,863,110)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)			
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		902,629	8,321,908
Орлогын татварын зардал	36	165,973	1,145,928
Татварын дараах ашиг (алдагдал)		736,656	7,175,980



НОГДОЛ АШГИЙН ТАЙЛАН

2021 оны цэвэр ашгаас ногдол ашиг олгох тухай шийдвэрийг 2022 оны 2 сарын 16-ны өдөр ТУЗ-ийн эчнээ санал хураалтаар шийдвэрлэсэн. Тус шийдвэрээр 2021 оны цэвэр ашгаас нийт 1 тэрбум төгрөгийг мөнгөн хэлбэрээр тооцож, нэгж хувьцаанд 40 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсний дагуу 2022 оны 7 сарын 28-ны өдөр ҮЦТХТ-тэй ногдол ашиг тараалгах гэрээ байгуулан хувьцаа эзэмшигчдийн ҮЦТХТ дэх хувьцааны дансаар дамжуулан ногдол ашгийг бүрэн олголоо.

Ногдол ашгийг 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийн өдрөөр буюу 2022 оны 4 сарын 4-ний байдлаар Ард Даатгал ХК-ийн хувьцааг эзэмшиж байгаа нийт хувьцаа эзэмшигчдэд олголоо.



8,142

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДДЭЭ

₮1 тэрбум

НОГДОЛ АШИГ ТАРААЛАА

Ард Даатгал ХК

Хүчтэй. Хамтдаа.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлуудаар шийдвэр гаргаж ажилладаг.

2021 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТУЗ-ийн гишүүдийг 2 жилийн хугацаатай сонгосон бөгөөд Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-д “Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна” гэж заасны дагуу өнөөдрийн байдлаар 6 ердийн, 3 хараат бус гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2022 онд нэг удаа эчнээгээр, таван удаа ээлжит хурал зохион байгуулсан бөгөөд хурлаар ногдол ашиг олгох тухай, ХЭХ хуралдуулах тухай, компанийн төсөв, улирал, жилийн эцсийн тайлан, аудитлагдсан тайлан болон бусад цаг үеийн асуудлуудыг хэлэлцэж шийдвэрүүд гаргаж ажилласан байна. Мөн Ард Даатгал ХК-ийн ТУЗ нь компанийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар явуулах зорилгоор Аудитын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Санхүү, эрсдэл, хөрөнгө оруулалтын хороотой байна.

2022 онд ТУЗ-ийн хувьд ээлжит болон эчнээ санал хураалт зэргийг хуваарийн дагуу амжилттай зохион байгуулж, зохих шийдвэрүүдийг гаргаж ажиллаа. Хурал болсон огноо:

1. 2022 оны 2 сарын 16-ны өдөр эчнээ (саналын хуудсаар)
2. 2022 оны 3 сарын 16-ны өдөр ээлжит
3. 2022 оны 4 сарын 27-ны өдөр ээлжит
4. 2022 оны 7 сарын 22-ны өдөр ээлжит
5. 2022 оны 10 сарын 26-ны өдөр ээлжит
6. 2022 оны 12 сарын 15-ны өдөр ээлжит

2022 онд ТУЗ-ийн бүтцэд өөрчлөлт орсон бөгөөд ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг өөрийн хүсэлтээр ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөж, ТУЗ-ийн гишүүн О.Одбаярыг ТУЗ-ын даргаар томилох шийдвэр гарсан. Мөн ТУЗ-ийн түр гишүүнээр Г.Уянга сонгогдож ажиллах шийдвэрүүд тус тус гарсан байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

ТУЗ-ийн дарга



Одончимэд
Одбаяр
ТУЗ-ийн гишүүн
Ард Санхүүгийн Нэгдэл ХК

Ердийн гишүүд



Галбадрах
Цогбадрах
Гүйцэтгэх захирал
Ард Даатгал ХК



Галням
Уянга
Гүйцэтгэх захирал
Ард Пропертиз ХХК



Батбилэг
Золбоо
Санхүү эрхэлсэн захирал
Ард Санхүүгийн Нэгдэл ХК



Чулуун
Ганзориг
Гүйцэтгэх захирал
Ард Экс ХХК



Сүхдорж
Оргил
Гүйцэтгэх захирал
Мост Финтек ХХК



Хараат бус гишүүд




Зоригт
Ариун
Төслийн удирдагч
Занаду Резиденс



Баатарзоригт
Болорчимэг
Үүсгэн байгуулагч
Өрөг.МН



Ичинхорлоо
Сэр-Од
Захирал
Монголын бизнес мэдээллийн бааз



2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, харилцагч, даатгуулагчид болон хамтран зүтгэгчид та бүхэнд компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулж байна.

2022 оны хувьд дэлхий даяар эдийн засгийн байдал тогтворгүй, Ковидын дараах эдийн засгийн сэргэлт удааширсан, Орос, Украины дайнаас шалтгаалсан эдийн засгийн тогтворгүй байдал үргэлжилсэн онцгой үйл явдлуудаар дүүрэн жил болсон хэдий ч Ард Даатгал ХК-ийн хувьд өөрсдийн нөөц боломжоо ашиглан хураамжийн орлогыг өнгөрсөн оны мөн үеэс 36 хувиар өсч, төсвөөс 10 хувиар давуулан нийт 22.3 тэрбум төгрөг хуримтлуулснаар хамгийн өндөр хураамжийн орлоготой ажиллаж, хосолсон харьцаа 99.8 хувьтай гарч, цэвэр ашиг 737 сая төгрөгт хүрч ажилласан байна. Тайлант онд даатгалын үндсэн системийн шинэ хувилбар нэвтрүүлж, нөхөн төлбөр хүлээн авах, санхүүгийн гүйлгээг хурдасгах, даатгалын бүртгэл сайжруулж, бусад систем, аппликэштэй холбох, иргэдийн даатгал, нөхөн төлбөрийн үйл ажиллагааг цахимжуулах зэрэг цоо шинэ боломжуудыг зах зээлд бий болгон ажиллаа.

ТУЗ нь улирал бүр компанийн дэвшүүлсэн зорилт, хэрэгжүүлж буй арга хэмжээ, төлөвлөгөөт ажлуудын үр дүнг хэлэлцэж, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг чиглүүлэх, санал, шүүмжлэл хэлж, засаж залруулж ирсэн. ТУЗ-ийн зүгээс гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлсэн ажлын үр дүнд сэтгэл хангалуун байгаа ба компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлд хангалттай гэсэн дүгнэлтийг хийж, компанийн Гүйцэтгэх захиралд бүрэн итгэл хүлээлгэн ирээдүйд тавьсан зорилго, зорилтууддаа хүрэхэд ТУЗ-ийн зүгээс бүх талаар дэмжин ажиллах болно.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигч:



Одончимэд **Одбаяр**

Төрсөн он сар: 1966.8

Иргэншил: Монгол

Сургуулийн нэр	Байршил	Элссэн он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил
Отгонтэнгэр Их Сургууль	Монгол, Улаанбаатар	1997	2000	Эрх зүйч
Техникийн Их Сургууль	АНУ, Флорида	1996	1997	Олон улсын эдийн засагч
Багшийн Их Сургууль	Украин, Киев	1984	1988	Багш

Байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
Ард Санхүүийн Нэгдэл ХК	ТУЗ-ийн гишүүн	2014-одоог хүртэл
Ард Даатгал ХК	ТУЗ-ийн гишүүн	2015-одоог хүртэл
Ард Кредит ББСБ ХК	ТУЗ-ийн гишүүн	2015-одоог хүртэл
Эрдэнэс Монгол ХХК	Бизнес хөгжил эрхэлсэн дэд захирал	2016-?
Эрдэнэс Стийл ХХК, Шивээ Овоо ХК	ТУЗ-ийн дарга	2016-?
Чингис Хаан Зочид Буудал Цогцолбор ХХК	Гүйцэтгэх захирал	2012-2015
Алтай Холдинг ХХК	Дэд ерөнхийлөгч	2012-2015
Монгол Улсын Засгийн Газар	Монгол Улсын Ерөнхий Сайдын зөвлөх	2010-2012
Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ	Атташе, Гуравдугаар нарийн бичгийн дарга	2005-2010
МИАТ ХК	Бээжин дэх төлөөлөгч	2002-2004
Монгол-Хятадын хамтарсан Си Эм Эйч төрийн өмчит компани	Монгол талын Гүйцэтгэх захирал	2000-2002
Монгол Улсын Их Сургууль	Багш	1988-1992



Галням **Уянга**
Төрсөн он сар: 1982.2
Иргэншил: Монгол

Сургуулийн нэр	Байршил	Элссэн он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил
СЭЗДС	Монгол, Улаанбаатар	1998	2002	Банк санхүү

Байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
Ард Пропертиз ХХК	Гүйцэтгэх захирал	2019-одоог хүртэл
Арван гэрийн холбоо	Гүйцэтгэх захирал	2009-2019
НҮБ төсөл	Гүйцэтгэх захирал	2005-2009





Галбадрах **Цогбадрах**

Төрсөн он сар: 1975.2

Иргэншил: Монгол

Сургуулийн нэр	Байршил	Элссэн он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил
АНУ-ын Үндэсний Их Сургууль	АНУ, Лос Анжелес	2009	2010	Бизнесийн удирдлагын магистр
Монгол Улсын Их Сургууль	Монгол, Улаанбаатар	1993	1997	Санхүүгийн менежмент, банкны эдийн засгийн бакалавр

Байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
Ард Даатгал ХК	Гүйцэтгэх захирал	2017-одоог хүртэл
Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Ард Секюритиз ҮЦК, Ард Менежмент ҮЦК	ТУЗ-ийн гишүүн	2015-2017
Тэнгэр Даатгал ХХК	Гүйцэтгэх захирал	2011-2014
ХасБанк	Дотоод аудит, салбарын удирдлага, Санхүү бүртгэл, Хөрөнгө зохицуулалтын газрын захирал	2000-2008
Голомт банк	Гадаад төлбөр тооцооны нябо	1996-1997



Батбилэг **Золбоо**
Төрсөн он сар: 1996.1
Иргэншил: Монгол

Сургуулийн нэр	Байршил	Элссэн он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил
Платсбург Коллеж	АНУ, Нью Йорк	2013	2016	Санхүү, нягтлан бодох бүртгэл
СЭЗИС	Монгол, Улаанбаатар	2012	2013	Олон улсын мэргэшсэн нягтлан бодогч

Байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
Ард Санхүүийн Нэгдэл ХК	Санхүү эрхэлсэн захирал	2018-одоог хүртэл
Ард Менежмент ҮЦК ХХК	Гүйцэтгэх захирал	2017-2018
Ард Секюритиз ҮЦК ХХК	Хөрөнгө оруулалтын шинжээч	2016-2017





Чулуун **Ганзориг**

Төрсөн он сар: 1986.11

Иргэншил: Монгол

Сургуулийн нэр	Байршил	Элссэн он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил
Корвинус Эдийн Засгийн Их Сургууль	Унгар, Будапешт	2007	2010	Бизнес менежментийн бакалавр

Байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
Ард Экс ХХК	Гүйцэтгэх захирал	2020-одоог хүртэл
Ард Кредит ББСБ ХК	Гүйцэтгэх захирал	2013-2019
Ард Даатгал ХК	ТУЗ-ийн гишүүн	2018-одоог хүртэл
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	Санхүү эрхэлсэн захирал	2017-2018
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	Хөрөнгө оруулалтын шинжээч	2012-2013
Ард Секюритиз ҮЦК ХХК	Хөрөнгө оруулалтын шинжээч	2010-2012



Сүхдорж **Оргил**
Төрсөн он сар: 1980.6
Иргэншил: Монгол

Сургуулийн нэр	Байршил	Элссэн он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил
Сиднейн технологийн их сургууль	Австрали, Сидней	2002	2006	Програм хангамжийн инженер
Колорадогийн их сургууль	АНУ, Колорадо	1998	2000	Ерөнхий

Байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
ПостКэйр ХХК	Гүйцэтгэх захирал	2014-одоог хүртэл
Мост Финтек ХХК	Захирал	2012-одоог хүртэл
Мост ПСП ХХК	Ерөнхий захирал	2009-2012
Гаалийн Ерөнхий Газар	МХТ/Худалдан авалт хариуцсан мэргэжилтэн	2007-2009
Мост Өртөө ХХК	Гүйцэтгэх захирал	2006-одоог хүртэл



Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигч:**Зоригт Ариун**

Төрсөн он сар: 1988.8

Иргэншил: Монгол

Сургуулийн нэр	Байршил	Элссэн он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил
INSEAD	Сингапур	2013	2014	Бизнесийн удирдлагын магистр
Valparaiso University	АНУ, Индиана	2006	2010	Бизнесийн удирдлага болон банк санхүүгийн бакалавр

Байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
Улаанбаатар хот дахь Америк сургууль	Зөвлөх	2016-одоог хүртэл
Insignia ХХК	Үүсгэн байгуулагч, захирал	2012-одоог хүртэл
Одод ХХК	Бизнес хариуцсан менежер	2012-2013
Улаанбаатар хот дахь Америк сургууль	Бизнес хариуцсан менежер	2010-2012



Баатарзоригт **Болорчимэг**

Төрсөн он сар: 1991.4

Иргэншил: Монгол

Сургуулийн нэр	Байршил	Элссэн он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил
Хүмүүнлэгийн ухааны их сургууль	Монгол, Улаанбаатар	2015	2016	Бизнесийн удирдлагын магистр
Хэвлэлийн хүрээлэн	Монгол, Улаанбаатар	2011	2012	Сэтгүүлч

Байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
Өрөг.мн	Үүсгэн байгуулагч, Ерөнхий продюссер	2019-одоог хүртэл
NTV ТВ	Сэтгүүлч, Хөтлөгч	2016-2019
МЛС Трэйнинг ХХК	Сургагч багш	2013-одоог хүртэл
Шинэ дэлхий ТВ	Сэтгүүлч, Хөтлөгч	2012-2014





Ичинхорлоо **Сэр-Од**

Төрсөн он сар: 1976.8

Иргэншил: Монгол

Сургуулийн нэр	Байршил	Элссэн он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил
Монгол Улсын Их Сургууль	Монгол, Улаанбаатар	1995	1998	Хуульч
Орхон коллеж	Монгол	1993	1995	Референт

Байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
Монголын бизнес мэдээллийн бааз ТББ	Үүсгэн байгуулагч, Захирал	2014-одоог хүртэл
МУ дахь Пакистан улсын өргөмжит консул	Өргөмжит консул	2019-одоог хүтэл
Монголын бизнесийн зөвлөл	Дэд захирал	2008-2014
МҮХАҮТ	Гадаад харилцааны газрын мэргэжилтан, дарга	2002-2007
УИХ-ын Тамгын газар	Зохион байгуулагч	1999-2001



Зоригт **Оюунцацрал**

Төрсөн он сар: 1974.8

Иргэншил: Монгол

Сургуулийн нэр	Байршил	Элссэн он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил
СЭЗДС	Монгол, Улаанбаатар	2009	2013	Бизнесийн удирдлага PhD Доктор
HGU	Солонгос улс	2001	2003	Бизнесийн удирдлага Магистр
ЭЗКоллеж	Монгол, Улаанбаатар	1992	1995	Санхүүч, Эдийн засагч

Байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
СЭЗИС	Ахисан түвшний профессор	1996-одоог хүртэл
ДоБиЧи Консалтинг ХХК	Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал	2019-одоог хүртэл





Төмөр **Билгээ**
Төрсөн он сар: 1980.11
Иргэншил: Монгол

Сургуулийн нэр	Байршил	Элссэн он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил
Шихихутаг Их сургууль	Монгол, Улаанбаатар	1998	2002	Эрх зүйч

Байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
Эрдэнэс Баянбогд ХХК	Уул уурхайн газрын захирал	2023-одоог хүртэл
Монголын өмгөөлөгчдийн холбоо	Өмгөөлөгч	2004-2022



Даваасамбуу **Галхүү**

Төрсөн он сар: 1976.2

Иргэншил: Монгол

Сургуулийн нэр	Байршил	Элссэн он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил
МУИС ЭЗДС	Австрали, Сидней	1993	1997	Нягтлан бодогч, эдийн засагч
Кобе их сургууль	Япон, Кобе	2003	2005	Эдийн засгийн ухаан Магистр

Байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
PWC аудит Монгол	Зах зээлийн удирдагч, Менежер, Аудитор	2012-2022
Дэлхийн банк, Сангийн яам	Техникийн дотоод зөвлөх	2011-2012
Дэлхийн банк, Сангийн яам	Дотоод аудитор	2011-2012



Төсөл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 он 4 сар 29 өдөр

№1/23

Улаанбаатар хот

2022 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 2023 оны 4 сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын ... тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хавсралтаар баталсугай.

ДАРГА

О.ОДБАЯР

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 он 4 сар 29 өдөр

№02/23

Улаанбаатар хот


Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 2023 оны 4 сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр овогтой-ыг, хараат бус гишүүнээр овогтой.....-ыг тус тус сонгохыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн мэдээллийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлж, зохих зөвшөөрлийг авч ажиллахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Г.Баярбат)-д даалгасугай.

ДАРГА

О.ОДБАЯР



Хүчтэй. Хамтдаа.